

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-9

1. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар
2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 5-9

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
11 дүгээр сарын 28-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 31 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 22 цаг 05 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Очирбат, О.Цогтгэрэл;

Чөлөөтэй: П.Батчимэг;

Тасалсан: О.Батнайрамдал, Х.Булгантуяа, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Б.Найдалаа, Э.Одбаяр, А.Ундраа, С.Цэнгүүн, Л.Энх-Амгалан.

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын зөвлөх Б.Нандингэрэл, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу хураасан санал:

Р.Сэддорж: 1.Төслийн 2 дугаар хавсралтын 2.1.3.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааныг бууруулна.” гэснийг “Хөдөлмөрийн маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Хөдөлмөр, нийгмийн гурван талт

түншлэлийг бэхжүүлэх” гэснийг “Хөдөлмөр, нийгмийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх хүрээнд хамтын гэрээ хэлэлцээрийн чанарыг сайжруулах, тоог нэмэгдүүлэх” гэж, 3 дугаар хавсралтын 2.1.3.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааныг бууруулна.” гэснийг “Хөдөлмөрийн маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.6.1.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-4.2.44, 4.2.47, 4.5.8” гэж, “Салбар” баганад “70304 Гадаад улсад байгаа Монгол иргэдэд туслах” гэж “Үр дүн” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Баталгаат шуудан, цахим систем ашиглах, санал авах байрны тоог нэмэгдүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гадаад харилцааны яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж, 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.4” гэж, “Салбар” баганад “70304 Гадаад улсад байгаа Монгол иргэдэд туслах” гэж, “Үр дүн” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийн сонгуульд оролцсон хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 7.1” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: -, 2027: 10, 2028: 15, 2029: -, 2030: -” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 1
Бүгд: 16
93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураасан санал:

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед санал хураалгаж дэмжигдсэн Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Р.Сэддорж нарын гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 51 дэх мөр, мөн 4.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 51 дэх мөр тус тус нэмэх:

-4.1 дэх хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “51” гэж, “Бүс, аймаг” баганад “Улаанбаатар, төв” гэж, “Төсөл, арга

хэмжээний нэр” баганад “Улаанбаатар хот орчмын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн төсөл” гэж, “Үр дүн” баганад “5.6.1.1, 6.2.2.2” гэж, “Санхүүжилтийн хугацаа, хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Төсөвт өртөг /сая.төг/” баганад “3,560,000.0” гэж, “Санхүүжилтийн гүйцэтгэл” баганад “-” гэж, “2026-2030” баганад “3,560,000.0” гэж, “2026” баганад “0” гэж, “2027” баганад “356,000.0” гэж, “2028” баганад “1,424,000.0” гэж, “2029” баганад “1,424,000.0” гэж, “2030” баганад “356,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” баганад “Гадаад зээл” гэж, “Хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэж;

-4.2 дахь хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “51” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатар хот орчмын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн төсөл” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ажлын явц” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “-” гэж, “2026” баганад “-” гэж, “2027” баганад “10” гэж, “2028” баганад “50” гэж, “2029” баганад “90” гэж, “2030” баганад “100” гэж, “Хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэж гэснийг тогтоолын төслөөс хасах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Р.Сэддорж нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	8
Бүгд:	16

50.0 хувь буюу гуравны хоёроос доошгүйн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед зарчмын зөрүүтэй саналын 167, 171 дүгээрт санал хураалгаж дэмжигдсэн 1.1.1.1, 1.1.2.2 дахь заалтын “Шалгуур үзүүлэлт” баганыг 2026 онд хүрэх түвшнийг 36 дугаарт хураагдаж дэмжигдсэн 1.1.3.4 дэх заалтын “Шалгуур үзүүлэлт” баганыг 2026 онд хүрэх түвшинтэй нийцүүлж, 2026 онд “2025 оны түвшнээс дээгүүр” гэснийг “2,800,000 төгрөгөөс доошгүй” /түүнээс цааш улсын дундаж цалингаас доошгүй түвшинд хүргэнэ./ гэж өөрчлөх гэсэн горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	2
Бүгд:	16

87.5 хувь буюу гуравны хоёроос доошгүйн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 22 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 21 минут үргэлжилж, 31 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр 22 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
22 цаг 05 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны гишүүдийн оройн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар, Цэндийн Баатархүү, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Ринчиндоржийн Батболд, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвжавын Ганзориг, Болдын Жавхлан, Батжаргалын Заяабал, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Болдын Уянга, Мөнхчулууны Энхцэцэг, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 51,6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, эцсийн хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 1.Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 10 сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын өргөн мэдүүлсэн Монгол Улсыг 2026-аас 30 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 11 дүгээр сарын 28-ны өдөр хийж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлдэх үүрэг бүхий ажлын хэсгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэн гэсний дагуу саналуудыг бэлтгэн та бүхэнд танилцуулж байна.

Тухайлбал, 1.Төслийн 2 дугаар хавсралтын хөдөлмөр, нийгмийн 3 талт түншлэлийг бэхжүүлэх хүрээнд хамтын гэрээ хэлэлцээрийн чанарыг сайжруулах, тоог нэмэгдүүлэх. 2.Төслийн 2, 3 дугаар хавсралтад хилийн чанадад байгаа Монгол Улсад, Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ гэсэн дээрх саналуудыг холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулан гүйцээн боловсруулахаар танилцуулж байна. Ингээд нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын саналын томъёоллоор санал явуулахгүйгээр нээлттэй үлдээсэн дээрх зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье? Алга байна. Чуулганы нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг баримтлан санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу хураалгах санал.

Төслийн 2 дугаар хавсралтын 2.1.3.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааныг бууруулна.” гэснийг “Хөдөлмөрийн маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Хөдөлмөр, нийгмийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх” гэснийг “Хөдөлмөр, нийгмийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх хүрээнд хамтын гэрээ хэлэлцээрийн чанарыг сайжруулах, тоог нэмэгдүүлэх” гэж, 3 дугаар хавсралтын 2.1.3.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааныг бууруулна.” гэснийг “Хөдөлмөрийн маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.” гэж. Санал гаргасан ажлын хэсэг. Саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 87,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. 14 гишүүн дэмжлээ.

2.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.6.1.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-4.2.44, 4.2.47, 4.5.8” гэж, “Салбар” баганад “70304 Гадаад улсад байгаа Монгол иргэдэд туслах” гэж “Үр дүн” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Баталгаат шуудан, цахим систем ашиглах, санал авах байрны тоог нэмэгдүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гадаад харилцааны яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж, 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.4” гэж, “Салбар” баганад “70304 Гадаад улсад байгаа Монгол иргэдэд туслах” гэж, “Үр дүн” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийн сонгуульд оролцсон хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 7.1” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: -, 2027: 10, 2028: 15, 2029: -, 2030: -” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Сонгуулийн

ерөнхий хороо” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 15 гишүүн дэмжиж, 93,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц горимын санал гаргаж байна.

Г.Лувсанжамц: Оройн мэнд, маш орой болтол хуралдаж байгаа та бүхэндээ баярлалаа. Зарчмаа барьж ажиллая гэсэн санал гаргаж байна. Сая нэгдсэн чуулган дээр дэмжээгүй санал буюу 194 дүгээр санал байгаа Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг гишүүн, Сэддорж гишүүний гаргасан саналыг Байнгын хороон дээр 2/3-н дэмжлэгтэйгээр дэмжихгүй байх горимын саналын хураалт явуулж өгөх санал гаргаж байна.

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Сая Байнгын хороон дээр ямар санал дэмжигдсэн бэ гээд тэгэхээр 1 дүгээрт бид ажлын хэсэг дээр ингэж тохирсон. Тэр 4.4 дүгээр хавсралт дээр ямар ч нэгэн юм нэмэхгүй байя. Энэ саяын миний гаргасан санал болохоор 4.1 дүгээр хавсралт. Ажлын хэсэг дээр гарсан зарчимтай бол ерөөсөө зөрчилдөхгүй байгаа. Дээрээс нь бид ажлын хэсэг дээр юу тохирсон бэ гэхээр Байнгын хороо, ажлын хэсэг дээр ерөөсөө энэ саналыг авч үзэхгүй, Байнгын хороон дээрээ авч үзье гэдэг утгаараа өчигдөр Байнгын хороон дээрээ санал хураалгаад явсан байгаа.

2 дугаар асуудал болохоор та бүхэн мэдэж байгаа. Эрчим хүчний салбар өнөөдөр маш олон хэрэглэгчийг цахилгаан, дулаанаар хангаж чадахгүй, цахилгаан дамжуулах түгээх сүлжээ нь хэт ачаалагдсан байдалтай байгаа. Тэгээд дээрээс нь улсынхаа төсвөөс эрчим хүчний салбарт ерөөсөө төсөв зарцуулж чадахгүй байгаа. Энэ төслийн хувьд болохоор тэр нөгөө гаднын зээл, тусламж нь аль хэдийн шийдэгдчихсэн. Хэрвээ энэ төлөвлөгөө дээр сууж чадахгүй бол танайх урт хугацааныхаа төлөвлөгөө дээр сууж чадахгүй юм байна гээд тэр зээлийг одоо зарцуулж чадахгүй. Дээрээс нь энэ дээр улсын төсөв дээр ямар ч ачаалал үүсэхгүй. Эрчим хүчний салбар ер нь хэрэгжүүлсэн төслийнхөө хөрөнгө оруулалтыг өөрөө өөрөө нөхөөд явдаг. Тэгээд энэ бол нэгдүгээрт хар даа зам биш, эрчим хүч. Яагаад гэвэл ард түмэн эрчим хүчиндээ буюу анхан шатынхаа хэрэглээг нэг хангаад өгөөч, энэ асуудлыг шийдээд өгөөч гэж ерөөсөө л 3 дахь асуудлыг эрчим хүч гэж ярьж байгаа.

Тэгээд улсын төсвөөсөө ерөөсөө зарцуулахгүй. Та бүхэн мэдэж байгаа ноднин 200 тэрбум байсан, энэ жил 300 тэрбум байснаа 30 тэрбумыг нь хасчихсан. Тэгэхээр яаж энэ дамжуулах сүлжээгээ, яаж энэ түгээх сүлжээгээ өргөтгөх гээд байгаа юм бэ. Тэгээд нэг их том, том юм мэдэмхийрээд л, энэ чинь зарчмаа барья, зарчмаа, зарчмаа ажлын хэсэг дээр тохирсон шүү дээ. Энэ ажлын хэсэг дээр гарсан зарчимтай ерөөсөө зөрчилдөөгүй. Тэрийг сая Уянгахишиг гишүүн ч гэсэн хэлсэн шүү дээ. Ажлын хэсэг дээр гарсан зарчимтай бол энэ зөрчилдөөгүй. Тэр 4.4 дүгээр хавсралтыг бол ерөөсөө ажлын хэсэг ингээд юу болгочихсон. Энэ 4.1 дүгээр хавсралт байгаа 1-д.

2-т ажлын хэсэг дээр биш, Байнгын хороон дээрээ ийм саналуудыг хураагаад явъя гэдэг зарчмыг ажлын хэсэг дээрээ тохирсон. Тийм учраас ерөөсөө ажлын хэсэг дээр гарсан зарчимтай бол зөрчилдөөгүй. Ийм учраас энэ дээр манайхан тэр 2/3-оор унагаагаад өгөөч гэдэг саналыг дэмжихгүй байхыг хүсэж байна. Яагаад гэвэл ард түмэн эрчим хүчтэй, цахилгаантай байхыг хүсэж байгаа. Энэ бол эх үүсвэр

барих асуудал биш байхгүй юу, энэ чинь цахилгаан дамжуулах түгээх сүлжээг өргөтгөх дээр энэ эрчим хүчний салбарынхан явсаар байгаад нэг бага хүүтэй зээл олсон. Тэгээд тэр зээлийг одоо зарцуулахгүй тэр хавар луугаа орж ирнэ биз гэж ерөөсөө тэгж том юм ярьж болохгүй байхгүй юу даа. Эрчим хүчний салбар чинь өнөө маргаашгүй зогсчих гээд байна. Тийм. Тэгэхээр жоохон юманд бодитой хандмаар байна л даа. Зам биш шүү дээ. Зам байсан бол би зүгээр асуудал байхгүй. Ард түмэн асфальтан зам биш, асаалттай гэрэлтэй байхыг л хүсээд байгаа шүү дээ.

Р.Сэддорж: Санал нэг байна Энхцэцэг гишүүнтэй. Энэ саналыг бол, энэ саналыг нийслэл Улаанбаатар хотод хийгдэх ажлууд байгаа. Ингээд жалга довын үзлээр бол ямар ч хамаагүй. Би говийн бүсээс сонгогдсон хүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга. Тоггүй бол энэ их энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станц эд нарыг оруулаад, энэ хувийн хэвшлээс тог аваад, энэ дэд станцууд байхгүй, агаарын дамжуулах шугамуудаа нэмэхгүйгээр утаан баатар хэвээрээ л байна, юун дулаан баатар. Ийм учраас, тийм энийг та бүхэн маань санал гаргаж, энэ энд Энхцэцэг гишүүнтэй нэр бичигдсэний хувьд би тайлбарлаж хэлье. Би аймгийн Засаг даргаар, аймгийн орлогчоор ажиллаж байсан хүний хувьд тоггүй бол ер нь тэгээд юм ярилтгүй дээ. Тэр айлын хашаанд 220 оруулахгүйгээр, 380 оруулахгүйгээр том, том шугамууд хэрэггүй байдаг юм гэдгийг.

Ингээд саналыг танилцуулъя. 41.7.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 51 дэх мөр, мөн 4.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 51 дэх мөр тус тус нэмэх:

-4.1 дэх хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “51” гэж, “Бүс, аймаг” баганад “Улаанбаатар, төв” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатар хот орчмын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн төсөл” гэж, “Үр дүн” баганад “5.6.1.1, 6.2.2.2” гэж, “Санхүүжилтийн хугацаа, хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Төсөвт өртөг /сая.төг/” баганад “3,560,000.0” гэж, “Санхүүжилтийн гүйцэтгэл” баганад “-” гэж, “2026-2030” баганад “3,560,000.0” гэж, “2026” баганад “0” гэж, “2027” баганад “356,000.0” гэж, “2028” баганад “1,424,000.0” гэж, “2029” баганад “1,424,000.0” гэж, “2030” баганад “356,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” баганад “Гадаад зээл” гэж, “Хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэж;

-4.2 дахь хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “51” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатар хот орчмын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн төсөл” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ажлын явц” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “-” гэж, “2026” баганад “-” гэж, “2027” баганад “10” гэж, “2028” баганад “50” гэж, “2029” баганад “90” гэж, “2030” баганад “100” гэж, “Хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэж гэснийг тогтоолын төслөөс хасах зарчмын, горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. 2/3 нь дэмжвэл энэ төслөөс хасагдана, тэгээд 2/3 нь дэмжигдэхгүй бол хэвээрээ орно. Санал хураалт. 50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Тэмүүлэн гишүүн ажлын хэсгийн дарга.

Г.Тэмүүлэн: Энэ сая нөгөө чуулган дээр хураагдсан саналууд дээр 167, 171 гээд саналууд хураагдсан, тэгээд тэр боловсролын салбартай холбоотой. Энэ саналууд яах вэ нөгөө манай ажлын хэсгийн санал биш. Сүүлд өөр Байнгын хороон

дээр гишүүнээс гарсан санал байгаад байгаа. Энэ санал маань яг ажлын хэсгийн 36 дугаар саналтай тодорхой агуулгын хувьд нэг жоохон зөрчилдөх асуудал үүсээд байгаа. Нөгөө шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгүүд нь. Тэгэхээр энийг нийцүүлэх үүднээс тухайн тэр нөгөө нэг салбар дотор 2, 3 өөр агуулгатай хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт баганууд үүсэх гээд байгаа учраас энийг 2/3-оор хураалгаж нийцүүлэх ийм шаардлага бол байна гээд би та бүхэнд 2/3-оор хураалгах санал гаргаж байгаа.

Энэ зарчмын зөрүүтэй саналын 167, 171 дүгээрт хураагдаж дэмжигдсэн 1.1.1.1, 1.1.2.2 дахь заалтын “Шалгуур үзүүлэлт” баганыг 2026 онд хүрэх түвшнийг 36 дугаарт хураагдаж дэмжигдсэн 1.1.3.4 дэх заалтын “Шалгуур үзүүлэлт” баганыг 2026 онд хүрэх түвшинтэй нийцүүлж, 2026 онд “2025 оны түвшнээс дээгүүр” гэснийг “2,800,000 төгрөгөөс доошгүй” /түүнээс цааш улсын дундаж цалингаас доошгүй түвшинд хүргэнэ./ гэж өөрчлөх гээд байгаа. Тэгээд энэ болохоор яг өмнөх ажлын хэсгийн түвшинд манай Эрдэнэбат гишүүний гаргаж, дэмжигдсэн санал. Гэтэл сая 167, 171 дээр бол арай өөр агуулгатай түвшин, үзүүлэлт арай өөр болсон. Тэгэхээр энийг бол нэг талдаа нийцүүлж, нэг түвшинтэй, нэг салбар дотор нэг шалгуур юутайгаар явахгүй бол явцдаа салбар дотроо зөрчилдөөн үүсэх ийм асуудал байна л гэсэн ийм зүйл байгаа. Тэгэхээр та бүхэн маань энэ 2/3-оор дэмжиж өгөөч. Тэгвэл үндсэндээ адилхан шалгуур үзүүлэлт багануудтай болно л гэсэн ийм тайлбар хэлэх гэсэн юм.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн дарга Тэмүүлэн гишүүний гаргасан жигдэлж, нийцүүлэх горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Бэлдэх үү? Санал хураалт. 87,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. “Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн миний бие танилцуулна.

22.26 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан өндөрлөж байна. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА